ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2020 оны 06 сарын 30 өдөр Дугаар А/16 Мөрөн сум

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3 дах заалт, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх заалт, Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 27 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/53 дугаар тушаал, 2018 оны А/207 дугаар тушаалын тавдугаар хавсралтын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэг нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг 495.9 сая (Дөрвөн зуун ерэн таван сая есөн зуун мянга) төгрөгөөр тогтоосугай.

2. Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тойрогт нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

3. Энэхүү тушаалаар тогтоосон зардлын дээд хэмжээг нийтэд мэдээлэхийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын нийцлийн аудитын албаны ахлах аудитор (Э.Бат-Эрдэнэ)-т даалгасугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер (Ж.Отгончимэг)-т даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.ГАНБОЛД

2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн
А/16 дугаар тушаалын хавсралт

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧЭЭС ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ДЭЭД ХЭМЖЭЭ

Тойргийн дугаар	Тойргийн нутаг дэвсгэр	Зардлын дээд хэмжээ /сая төгрөгөөр/
1	Алаг-Эрдэнэ	67.9
2	Арбулаг	56.9
3	Баянзүрх	50.6
4	Бүрэнтогтох	59.6
5	Галт	58.4
6	Жаргалант	58.5
7	Их-Уул	52.5
8	Рашаант	50.2
9	Рэнчинлхүмбэ	61.6
10	Тариалан	74.6
11	Тосонцэнгэл	52.5
12	Төмөрбулаг	53.0
13	Түнэл	58.3
14	Улаан-Уул	57.8
15	Ханх сум	34.1
16	Хатгал тосгон	38.6
17	Цагааннуур	22.6
18	Цагаан-Уул	65.3
19	Цагаан-Үүр	38.9
20	Цэцэрлэг	66.8
21	Чандмань-Өндөр	47.1
22	Шинэ-Идэр	41.9
23	Эрдэнэбулган	46.4
24	Мөрөн 1 дүгээр баг	27.3
25	Мөрөн 2 дугаар баг	20.5
26	Мөрөн 3 дугаар баг	22.1
27	Мөрөн 4 дүгээр баг	23.1
28	Мөрөн 5 дугаар баг	19.8
29	Мөрөн 6 дугаар баг	21.7
30	Мөрөн 7 дугаар баг	28.3
31	Мөрөн 8 дугаар баг	21.3
32	Мөрөн 9 дүгээр баг	24.9
33	Мөрөн 10 дугаар баг	25.7
34	Мөрөн 11 дүгээр баг	21.2
35	Мөрөн 12 дугаар баг	20.8
36	Мөрөн 13 дугаар баг	28.4
37	Мөрөн 14 дүгээр баг	25.3

--ooOoo--